

ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорноговь аймгийн Сайншанд сумын хүүхдийн 4-р цэцэрлэгийн
2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ДГА-2023/138/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.dornogovi@audit.gov.mn

Дорноговь аймаг
Сайншанд сум
2023 он

Дарга, Тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий

Утас: 261665, 70522734
Цахим хаяг: gan-ulziit@audit.gov.mn

Аудитын менежер: У.Оюунтүлхүүр
Утас:70523020
Цахим хаяг: oyuntulkhuur.u@audit.gov.mn

Аудитор: Т.Оюунтуяа
Утас: 99048991

Цахим хаяг: oyuntuya@esanhuu.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Орон нутгийн өмчийн III байр, Залуучууд гудамж,
3 дугаар баг, Сайншанд сум, Дорноговь аймаг, 44103,
Утас: (705) 2-27-34

Цахим хуудас: dornogovi@audit.gov.mn

2023.02.29 № 1-6/194

танай _____-ны № _____-т

САЙНШАНД СУМЫН ХҮҮХДИЙН
4-Р ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
Б. БАТЦЭЦЭГ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Сайншанд сумын хүүхдийн 4-р цэцэрлэгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорноговь аймгийн Сайншанд сумын хүүхдийн 4-р цэцэрлэгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд тус байгууллагын үйл ажиллагаанд асуудлын онцлох хэсэгт дурдах асуудал илрээгүй болно.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь аудиторын мэргэжлийн шийдлээр тайлант хугацааны санхүүгийн тайлангийн аудитад чухал нөлөө үзүүлсэн асуудлуудыг авч үзэх бөгөөд 2022 онд боловсролын байгууллагыг үйл ажиллагааны үр дүн, чанар, гүйцэтгэл, сургалтын хөтөлбөрийн бодит өртөгт суурилсан хувьсах зардлаар санхүүжүүлэх, үр дүн, бүтээмжид суурилсан цалин хөлсний бодлого хэрэгжүүлэхэд чиглэсэн холбогдох эрх зүйн актуудыг шинэчлэн баталж, мөрдүүлсэн асуудлыг аудитын гол асуудал гэж үзлээ.

Дорноговь аймгийн Сайншанд сумын 4-р цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг өмнөх онтой харьцуулахад мөнгөн хөрөнгийн дансанд их хэмжээний өөрчлөлт орсон байна. Энэ нь Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан "Хувьсах зардлын

0100 04 2

дундаж нормативаар төсөв хуваарилах, санхүүжүүлэх журам"-ын 8.7 дахь заалтад төсвийн жилийн эцэст зарцуулагдаагүй үлдсэн мөнгөн хөрөнгийг улсын төсөвт татан төвлөрүүлэлгүйгээр дараагийн төсвийн жилд шилжүүлэн зарцуулахаар заасантай холбоотой мөнгөн хөрөнгийн данс 14.4 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Мөн Шилэн дансны цахим системд 7 хоногийн хугацаанд оруулбал зохих 366.6 сая төгрөгийн мэдээллүүдээс 254.2 сая төгрөгийн 16 гүйлгээ, 18.2 сая төгрөгийн 18 шийдвэрийг хугацаа хоцроосон, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 22.0 сая төгрөгийн орлогын 1 гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах 4.1 сая төгрөгийн 5 шийдвэрийг огт мэдээлээгүй байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 "Тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6.4 "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ:" 6.4.5 "Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр", 6.4.8 "бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр" заалтуудтай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Эд хариуцагчийн гаргасан тайланг ня-бо сар бүр хянаж шалгаагүй, бараа материалын тайланд барааг Сангийн Сайдын баталсан маягтын дагуу тоо ширхэгээр гаргаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20-р зүйлийн 20.1.3-т "аж ахуйн нэгж, байгууллагын хөрөнгийн орлого, зарлагын баримт болон санхүүгийн тайланд хоёрдугаар гарын үсэг зурах", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэсэн хуулийн заалтуудыг хангаж ажиллаагүй, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Бусад асуудлын хэсэг

2022 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд тусгагдсан 16 зорилт, 42 арга хэмжээний хэрэгжилт 88.3 хувь, хөтөлбөр, арга хэмжээнд зориулан зарцуулахаар төлөвлөж зарцуулсан төсвийн гүйцэтгэл 97.6 хувийн биелэлттэй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т. ГАН-ӨЛЗИЙ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	58,933,865.20	64,999,280.23
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	14,432,375.03
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	-	14,432,375.03
3121	Төгрөг	-	14,432,375.03
31211	Төрийн сангийн харилцах	-	14,432,375.03
33	АВЛАГА	6,375,000.00	-
335	Бусад авлага	6,375,000.00	-
3351	Байгууллагаас авах авлага	6,375,000.00	-
35	БАРАА МАТЕРИАЛ	52,558,865.20	50,566,905.20
351	Түүхий эд материал	1,421,780.00	1,719,200.00
35110	Тусгай зориулалттай материал	425,580.00	1,082,200.00
35130	Эм боох материал	996,200.00	637,000.00
354	Хангамжийн материал	51,137,085.20	48,847,705.20
35410	Бичиг хэргийн материал	1,383,805.00	639,305.00
35420	Аж ахуйн материал	42,713,988.00	42,669,288.00
35450	Барилгын засварын материал	1,811,000.00	1,508,450.00
35460	Хүнсний материал	3,811,942.20	2,838,262.20
35470	Бусад хангамжийн материал	1,416,350.00	1,192,400.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	517,838,497.16	494,922,517.05
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	517,838,497.16	494,922,517.05
392	Биет хөрөнгө	474,009,122.37	451,208,642.26
39201	Барилга, байгууламж, орон сууц	470,218,358.35	470,218,358.35
39202	Хуримтлагдсан элэгдэл	(43,862,612.88)	(58,483,483.80)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	48,897,695.00	37,951,430.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(21,362,576.59)	(16,098,048.39)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	34,941,392.80	28,298,858.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(17,615,045.41)	(11,550,699.13)
39214	Бусад үндсэн хөрөнгө	647,965.23	647,965.23
39215	Хуримтлагдсан элэгдэл	(351,618.84)	(416,131.00)
39217	Ном	2,495,564.71	640,393.00
393	Биет бус хөрөнгө	43,829,374.79	43,713,874.79
39301	Програм хангамж	627,000.00	627,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(317,625.21)	(433,125.21)
39303	Бусад биет бус хөрөнгө	43,520,000.00	43,520,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	576,772,362.36	559,921,797.28
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	576,772,362.36	559,921,797.28
51	Засгийн газрын хувь оролцоо	576,772,362.36	559,921,797.28
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	186,350,442.87	186,350,442.87
51101	Өмч: - төрийн	186,350,442.87	186,350,442.87
512	Хуримтлагдсан үр дүн	131,830,833.99	356,264,606.41
51210	Өмнөх үеийн үр дүн	131,830,833.99	379,685,933.34
51220	Тайлант үеийн үр дүн	-	(23,421,326.93)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	258,591,085.50	17,306,748.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	576,772,362.36	559,921,797.28

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	418,996,096.72	417,664,897.93
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	4,809,500.00
120	Нийтлэг татварын бус орлого	-	4,809,500.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	4,809,500.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	-	4,809,500.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	418,996,096.72	412,855,397.93
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	380,235,500.00	355,213,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	355,213,300.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	380,235,500.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	4,725,000.00	210,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,000,000.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	725,000.00	210,000.00

1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	34,035,596.72	57,432,097.93
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	34,035,596.72	57,432,097.93
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	373,106,414.44	439,231,053.15
21	УРСГАЛ ЗАРДАЛ	373,106,414.44	439,231,053.15
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	369,079,036.14	436,071,053.15
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	261,216,300.00	283,113,208.17
210101	Үндсэн цалин	182,410,600.00	216,661,009.89
210102	Нэмэгдэл	51,901,400.00	62,130,497.39
210103	Унаа хоолны хөнгөлөлт	7,308,000.00	-
210104	Урамшуулал	19,596,300.00	4,321,700.89
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	33,919,961.70	35,526,404.28
210201	Тэтгэврийн даатгал	24,319,461.70	24,233,355.77
210202	Тэтгэмжийн даатгал	2,400,100.00	2,803,720.69
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,920,000.00	2,283,710.70
210204	Ажилгүйдлийн даатгал	480,100.00	551,060.80
210205	Эрүүл мэндийн даатгал	4,800,300.00	5,654,556.32
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	32,037,646.72	39,074,154.08
210301	Гэрэл, цахилгаан	1,780,677.72	3,302,186.08
210302	Түлш, халаалт	27,490,848.00	28,682,500.00
210303	Цэвэр, бохир ус	2,766,121.00	7,089,468.00
2104	Хангамж, бараа материалын зардал	6,231,090.00	2,051,530.00
210401	Бичиг хэрэг	392,150.00	409,100.00
210402	Тээвэр, шатахуун	500,000.00	-
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	223,400.00	-
210404	Ном, хэвлэл	-	183,580.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,006,750.00	361,700.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,106,990.00	1,097,150.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	1,800.00	-
2105	Нормативт зардал	11,662,700.00	37,430,530.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	172,900.00	-
210502	Хоол, хүнс	9,369,600.00	36,541,030.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,120,200.00	889,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	430,290.00	1,212,365.00
210604	Урсгал засвар	430,290.00	1,212,365.00
2107	Томиллолт, зочны зардал	290,000.00	-
210702	Дотоод албан томиллолт	290,000.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,057,200.00	671,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	769,200.00	-
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	288,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	671,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	22,233,847.72	36,991,861.62
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	6,770,753.22
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	816,250.00	4,350,800.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	21,417,597.72	25,870,308.40
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,027,378.30	3,160,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	200,000.00	3,160,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	200,000.00	3,160,000.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	3,827,378.30	-
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,827,378.30	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	45,889,682.28	(21,566,155.22)
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	1,855,171.71
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	1,855,171.71
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	(1,855,171.71)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	45,889,682.28	(23,421,326.93)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	418,996,096.72	419,426,159.78
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	6,570,761.85
120	Нийтлэг татварын бус орлого	-	6,570,761.85
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	6,570,761.85
1200047	Ахмадын сангийн шилжиж ирсэн эхний үлдэгдэл	-	6,570,761.85
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	418,996,096.72	412,855,397.93

1310	Улсын төвлөрсөн төсвөөс	380,235,500.00	355,213,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	355,213,300.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	380,235,500.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	4,725,000.00	210,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,000,000.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	725,000.00	210,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	34,035,596.72	57,432,097.93
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	34,035,596.72	57,432,097.93
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	386,306,906.72	404,993,784.75
21	УРСГАЛ ЗАРДАЛ	386,306,906.72	404,993,784.75
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	382,279,528.42	401,833,784.75
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	261,216,300.00	283,113,208.17
210101	Үндсэн цалин	182,410,600.00	216,661,010.19
210102	Нэмэгдэл	51,901,400.00	62,130,497.39
210103	Унаа хоолны хөнгөлөлт	7,308,000.00	-
210104	Урамшуулал	19,596,300.00	4,321,700.59
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	33,919,961.70	35,526,404.28
210201	Тэтгэврийн даатгал	24,319,461.70	24,251,541.38
210202	Тэтгэмжийн даатгал	2,400,100.00	2,789,021.90
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,920,000.00	2,289,096.37
210204	Ажилгүйдлийн даатгал	480,100.00	550,238.01
210205	Эрүүл мэндийн даатгал	4,800,300.00	5,646,506.62
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	32,037,646.72	39,074,154.08
210301	Гэрэл, цахилгаан	1,780,677.72	3,302,186.08
210302	Түлш, халаалт	27,490,848.00	28,682,500.00
210303	Цэвэр, бохир ус	2,766,121.00	7,089,468.00
2104	Хангамж, бараа материалын зардал	19,193,350.00	-
210401	Бичиг хэрэг	300,000.00	-
210402	Тээвэр, шатахуун	500,000.00	-
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	223,400.00	-
210404	Ном, хэвлэл	28,000.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,166,950.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	16,975,000.00	-
2105	Нормативт зардал	24,787,270.00	29,192,350.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	62,800.00	-
210502	Хоол, хүнс	19,529,470.00	29,192,350.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	5,195,000.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,806,750.00	1,194,165.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,808,800.00	-
210604	Урсгал засвар	1,997,950.00	1,194,165.00
2107	Томилолт, зочны зардал	290,000.00	-
210702	Дотоод албан томилолт	290,000.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,057,200.00	814,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	769,200.00	-
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	288,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	814,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,971,050.00	12,919,503.22
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,500,000.00	9,171,503.22
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,471,050.00	3,748,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,027,378.30	3,160,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	200,000.00	3,160,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	200,000.00	3,160,000.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	3,827,378.30	-
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,827,378.30	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	32,689,190.00	14,432,375.03
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	32,689,190.00	-
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	32,689,190.00	-
2200	Дотоод эх үүсвэрээр	32,689,190.00	-
222001	Тоног төхөөрөмж	18,057,190.00	-
223001	Бусад хөрөнгө	14,632,000.00	-
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(32,689,190.00)	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	0.00	14,432,375.03
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	14,432,375.03

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	186,350,442.87	258,591,085.50	85,865,751.71	530,807,280.08
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	186,350,442.87	258,591,085.50	85,865,751.71	530,807,280.08
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	45,965,082.28	45,965,082.28
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	186,350,442.87	258,591,085.50	131,830,833.99	576,772,362.36
D01	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	186,350,442.87	258,591,085.50	131,830,833.99	576,772,362.36
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	247,855,099.35	247,855,099.35
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	186,350,442.87	258,591,085.50	379,685,933.34	824,627,461.71
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	(241,284,337.50)	-	(241,284,337.50)
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(23,421,326.93)	(23,421,326.93)
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	186,350,442.87	17,306,748.00	356,264,606.41	559,921,797.28

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл			
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	415,007,700.00	404,993,784.75	10,013,915.25
21	УРСГАЛ ЗАРДАЛ	415,007,700.00	404,993,784.75	10,013,915.25
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	415,007,700.00	401,833,784.75	13,173,915.25
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	285,180,800.00	283,113,208.17	2,067,591.83
210101	Үндсэн цалин	238,595,200.00	216,661,010.19	21,934,189.81
210102	Нэмэгдэл	43,270,500.00	62,130,497.39	(18,859,997.39)
210104	Урамшуулал	3,315,100.00	4,321,700.59	(1,006,600.59)
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	35,758,400.00	35,526,404.28	231,995.72
210201	Тэтгэврийн даатгал	24,315,600.00	24,251,541.38	64,058.62
210202	Тэтгэмжийн даатгал	2,860,700.00	2,789,021.90	71,678.10
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,288,600.00	2,289,096.37	(496.37)
210204	Ажилгүйдлийн даатгал	572,200.00	550,238.01	21,961.99
210205	Эрүүл мэндийн даатгал	5,721,300.00	5,646,506.62	74,793.38
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	41,323,900.00	39,074,154.08	2,249,745.92
210301	Гэрэл, цахилгаан	4,977,600.00	3,302,186.08	1,675,413.92
210302	Түлш, халаалт	28,682,500.00	28,682,500.00	-
210303	Цэвэр, бохир ус	7,663,800.00	7,089,468.00	574,332.00
2105	Нормативт зардал	38,208,400.00	29,192,350.00	9,016,050.00
210502	Хоол, хүнс	38,208,400.00	29,192,350.00	9,016,050.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,200,000.00	1,194,165.00	5,835.00
210604	Урсгал засвар	1,200,000.00	1,194,165.00	5,835.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	814,000.00	814,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	814,000.00	814,000.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	12,522,200.00	12,919,503.22	(397,303.22)
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,772,200.00	9,171,503.22	(399,303.22)
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,750,000.00	3,748,000.00	2,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	3,160,000.00	(3,160,000.00)
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	3,160,000.00	(3,160,000.00)
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	3,160,000.00	(3,160,000.00)
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	415,007,700.00	412,855,397.93	2,152,302.07
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	355,319,800.00	355,213,300.00	106,500.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	355,319,800.00	355,213,300.00	106,500.00

1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	59,687,900.00	57,432,097.93	2,255,802.07
132001	Орон нутгийн төсвөөс	59,687,900.00	57,432,097.93	2,255,802.07
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	-	210,000.00	(210,000.00)
120010	Нэмэлт санхүүжилтийн үлдэгдлээс санхүүжих		210,000.00	(210,000.00)
120004 7	Ахмадын сангийн шилжиж ирсэн эхний үлдэгдэл		6,570,761.85	(6,570,761.85)
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		14,432,375.03	(14,432,375.03)
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00	-
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00	-
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	21.00	21.00	-
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	-
620002	Гүйцэтгэх ажилтан	11.00	11.00	-
620003	Үйлчлэх ажилтан	9.00	9.00	-

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	210,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	210,000.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	210,000.00
213305	Нэмэлт санхүүжилтийн үлдэгдэл төвлөрүүлэх шилжүүлэг		210,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	210,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	210,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		210,000.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 249.7 сая төгрөгийн 3 алдаа¹ илэрснээс аудитын явцад 249.7 сая төгрөгийн 3 алдааг залрууллаа.

Залруулсан алдаа:

1. Улсын төсвийн данснаас ахмадын сангийн дансанд шилжүүлсэн 2.0 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн ажил гүйлгээг үр дүнгийн тайланд орлого, зардлаар бүртгэснийг, 6.6 сая төгрөгийн ахмадын сангийн мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдлийг алдаатай бүртгэснийг залруулсан;
2. Дахин үнэлгээний нэмэгдлийг 241.1 сая төгрөгөөр илүү бүртгэснийг залруулсан;

Аудитаар нийт 3 зөрчил² илэрснээс 0.9 сая төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 2 зөвлөмж өгсөн.

3.1 Төлбөрийн акт

Тайлант хугацаанд 2022 оны ажлын үр дүнг үнэлж, сумын Засаг даргын захирамжийг үндэслэн байгууллагын удирдах албан тушаалтанд 12 дугаар сард үндсэн цалингийн 80 хувиар буюу 0.9 сая төгрөгийг тооцож олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.20-д “Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга тухайн шатны орон нутгийн энэ хуулийн 14.1.18, 14.1.19-д зааснаас бусад төсвийн”, 16 дугаар зүйлийн 16.5.2-т “Батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих”, 16.5.5-д “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

3.3 Зөвлөмж

1. Дотоод хяналттай холбоотой асуудал

Илрүүлэлт: Эд хариуцагчийн гаргасан тайланг ня-бо сар бүр хянаж шалгаагүй, бараа материалын тайланд барааг Сангийн Сайдын баталсан маягтын дагуу тоо ширхэгээр гаргаагүй нь өмч, хөрөнгө дутагдах, ашиггүй зарцуулагдах, бодитой мэдээллээр хангагдаж чадахгүй байх үр дагавартай.

Мөн Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20-р зүйлийн 20.1.3-т “аж ахуйн нэгж, байгууллагын хөрөнгийн орлого, зарлагын баримт болон санхүүгийн тайланд хоёрдугаар гарын үсэг зурах”, 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэсэн хуулийн заалтуудыг хангаж ажиллаагүй, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Нягтлан бодогч сар бүр эд хариуцагчийн тайланг хянан, тоо ширхэгийг тодорхой гаргаж, гарын үсэг болон бусад баталгаажуулалтыг ханган хариуцлагатай ажиллах.

2. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Тус байгууллагын Шилэн дансны цахим системд 7 хоногийн хугацаанд оруулбал зохих 366.6 сая төгрөгийн мэдээллүүдээс 254.2 сая төгрөгийн 16 гүйлгээ, 18.2 сая төгрөгийн 18 шийдвэрийг хугацаа хоцроосон, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 22.0 сая төгрөгийн орлогын 1 гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах 4.1 сая төгрөгийн 5 шийдвэрийг огт мэдээлээгүй байна. Энэ нь төсөв, өмч, хөрөнгө, мөнгө

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

шамшигдуулах, орлого нуун дарагдуулах, зориулалтын бус, үр ашиггүй зарцуулалт хийгдэх үр дагавартай.

Мөн Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 “Тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”, 6.4 “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ.” 6.4.5 “Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр”, 6.4.8 “бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр” заалтуудтай нийцээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Шилэн дансанд мэдээлэл дутуу байршуулсан зөрчлийг арилгаж, давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллах

Дээрх зөвлөмж, албан шаардлагын биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2023 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Улсын төсвийн данснаас ахмадын сангийн дансанд шилжүүлсэн 2.0 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн ажил гүйлгээг үр дүнгийн тайланд орлого, зардлаар бүртгэснийг, 6.6 сая төгрөгийн ахмадын сангийн мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдлийг алдаатай бүртгэснийг залруулсан	1	8,614.8	0	-	1	8,614.8	1	8,614.8	0	-		
Дахин үнэлгээний нэмэгдлийг 241.0 сая төгрөгөөр илүү бүртгэснийг залруулсан;	1	241,051.4	0	-	1	241,051.4	1	241,051.4	0	-		
Дүн	3	249,666.2	-	-	3	249,666.2	3	249,666.2	-	-		

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн	
Эд хариуцагчийн гаргасан тайланг ня-бо сар бүр хянаж шалгаагүй, бараа материалын тайланд барааг Сангийн Сайдын баталсан маягтын дагуу тоо ширхэгээр гаргаагүй байна.	1						1						
Тайлант хугацаанд 2022 оны ажлын үр дүнг үнэлж, сумын Засаг даргын захирамжийг үндэслэн байгууллагын удирдах албан тушаалтанд 4 дүгээр сард үндсэн цалингийн 45 хувь, 12 дугаар сард 100 хувиар буюу нийт 1.6 сая төгрөгийг тооцож олгосон байна.	1	946.0	1	946.0									
Дүн	2	946.0	1	946.0			1						

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Тус байгууллагын Шилэн дансны цахим системд 7 хоногийн хугацаанд оруулбал зохих 366.6 сая төгрөгийн мэдээллүүдээс 254.2 сая төгрөгийн 16 гүйлгээ, 18.2 сая төгрөгийн 18 шийдвэрийг хугацаа хоцроосон, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 22.0 сая төгрөгийн орлогын 1 гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах 4.1 сая төгрөгийн 5 шийдвэрийг огт мэдээлээгүй байна.	1		-	-	-	-	1	
Дүн	1		-	-	-	-	1	

